



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 13,777,390.00 (арван гурван сая долоон зуун далан долоон мянга гурван зуун ерэн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.
2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадорж, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Т.Мөнхсайханд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
 - 2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;
 - 2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;
 - 2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
 - 2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000430



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн
дугаар тогтоодын хавсралт

ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААР ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арагал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн/Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдээгдэл өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	УАЗ Фургон- 22069-033, 39-66УНМ, Суудал, арагал-50306521, хөдөлгүүр-50447122	2005	135,726	13,777,390.00	13,777,390.00	-	3,850,000.00	8,000,000.00
	Нийт дүн	-	-	13,777,390.00 (арван гурван сая долоон зуун далан долоон мянга гурван зуун ерэн)	13,777,390.00 (арван гурван сая долоон зуун далан долоон мянга гурван зуун ерэн)	-	3,850,000.00 (гурван сая найман зуун тавин мянган)	8,000,000.00 (найман сая)